



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

Ард. 10.23 № 35-1/145

танай _____-ны № _____-т

**Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай**

“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224000378



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023. 10. 19 № ХХ/2353
танай _____-ны № _____-Т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

"Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000235004228




**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чангалтай дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mofha.gov.mn,
Цахим хуудас: www.mofha.gov.mn

2023.10.13 № 1/5326
танай 2023.10.05-ны № 1a/3625-т

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД
Г.САЙХАНБАЯР ТАНАА**

"Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.


Б.ЭНХБАЯР

1516048-2
Doc.yam a5.2023



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.10.11 № 01/7481

танай _____ -ны № _____ -т

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД
Г.САЙХАНБАЯР ТАНАА**

Таны ирүүлсэн "Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичигтэй танилцлаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002292

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлд:

"ХVI.ХЭЛЭЛЦСЭН нь: "Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: "Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



БАТЛАВ.
БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД

Т.САЙХАНБАЯР



БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗЭВСЭГ, ТЕХНИКИЙГ ШИНЭЧЛЭХ, СЭРГЭЭН САЙЖРУУЛАХ БОДЛОГЫГ БАТЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д "Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн" гэж, мөн зүйлийн 2-т "Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно" гэж тус тус заасан.

Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Зэвсэгт хүчний үндсэн чиг үүрэг нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах явдал мөн" гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3-т "зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг тодорхойлох" гэж Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхийг тус тус заажээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн мн/04 дүгээр тогтоолоор "Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2023 оны Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэхийг Батлах хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд чиглэл болгосон.

"Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13-т заасан Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой төрийн бодлогын баримт бичиг тул хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөлд хамаарахгүй юм.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага:

Монгол Улс цэргийн шинэчлэлийн гол зорилгоо "мэргэжлийн цэрэгт суурилсан, цэргийн мэргэжлийн өндөр бэлтгэлтэй бие бүрэлдэхүүн, орчин үеийн зэвсэглэл, цэргийн техник бүхий чадварлаг Зэвсэгт хүчнийг байгуулна" хэмээн тодорхойлсон билээ.

Олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлттэй холбогдуулан улс орнууд аюулгүй байдлын үзэл баримтлал, төрийн бодлогодоо

батлан хамгаалах төсөв, зардлаа нэмэгдүүлэх, зэвсэглэл, техникийг шинэчлэх бодлогыг баримталж байна.

Дэлхийн болон бүс нутгийн өнөөгийн цэрэг-улс төр, цэрэг-стратегийн нөхцөл байдал нь Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, нэн тэргүүнд зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн түвшингээс хоёроос дөрвөн үеэр хоцрогдож 75 хувь нь 35-45, түүнээс дээш жилийн ашиглалтын насжилттай, үйлдвэрлэгч оронд техникийн үйлдвэрлэл зогссон, галт хэрэглэл, тэжээлийн эх үүсгүүр болон бусад сэлбэг, дагалдах хэрэгслийн нөөц дутагдалтай, төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан ашиглалт, хадгалалтын технологийн горимыг алдагдуулж байна.

Тухайлбал, улсын нийслэл болон онц чухал объектыг агаараас довтлох хэрэгслээс хамгаалах зориулалттай "Печора-2М" С-125М загварын зенит пуужингийн цогцолбор нь техник, программ хангамжийн гэмтэлтэй тул засварлах, агаарын зайд хяналт явуулах зориулалттай радиолокацын станцын 90 хувьд сэргээн сайжруулах засвар, үйлчилгээ хийх, онгоц, нисдэг тэрэгний 36 хувийн ашиглалтын хугацааг сунгах шаардлага үүсээд байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг "АЛСЫН ХАРАА-2050", "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030", "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө"-нд дэвшүүлсэн тодорхой зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж байгаа хэдий ч эдийн засгийн боломжоос шалтгаалж зэвсэглэл, техникийн шинэчлэлд төсвийн хөрөнгө оруулалт хийж чадахгүй хэвээр байна.

Дээрх хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг төрөөс тодорхойлж, гадаадын орнуудын зээл тусламжаар шинэчлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдаж авах замаар хэрэгжүүлэх юм.

Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх зорилгод нийцүүлэн байлдааны зэвсэг, цэргийн техникийг шинэчлэх бодлогыг дараах үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэгдүгээрт: Зэвсэглэл, цэргийн техникийн ашиглалт, хадгалалтыг технологийн горимын дагуу зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж хэрэгжүүлэх;

Хоёрдугаарт: Зэвсэглэл, цэргийн техникт төсвийн бодлогоор баталгаажсан төлөвлөгөөний дагуу сэргээн сайжруулах засвар, техникийн үйлчилгээ хийх;

Гуравдугаарт: Зэвсэглэл, цэргийн техникийг цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд гадаад орнуудын зээл тусламжаар шинэчлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдаж авах;

Дөрөвдүгээрт: Дотоод нөөц бололцоондоо тулгуурлан орчин үеийн технологийн ололт, шийдлийг нутагшуулж, цэргийн зарим төрлийн техник, хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэх;

Бодлогын баримт бичгийн төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13-д заасны дагуу үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлыг хөндсөн тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан аргачлалын дагуу холбогдох судалгаануудыг боловсруулах шаардлагагүй гэж үзсэн болно.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Энэхүү бодлогын баримт бичиг нь Дэлхийн ба бүс нутгийн цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн нөхцөл байдал, Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн өнөөгийн байдал, Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын чиглэл, Зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо гэсэн 4 бүлгээс бүрдэнэ.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар:

“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлого, цэргийн урлагийн хөгжлийн чиг хандлага, Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэгт нийцсэн, шинжлэх ухааны ололт, инновац, дэвшилтэт технологид суурилсан өндөр бүтээмжтэй зэвсэглэл, цэргийн техникээр нөхөн хангагдах эрх зүйн болон төсөв, санхүүгийн үндэс бүрдэж, дараах эерэг үр дүнд хүрч, боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Үүнд:

1.Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 4.7-д заасан “Зэвсэгт хүчний зэвсэглэлийг үе шаттай шинэчилж байх уян хатан тогтолцоо бүрдүүлнэ. Цэргийн зэвсэг, техник худалдан авахад зориулан батлан хамгаалах зардлын тодорхой хэсгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байна.”, Батлан хамгаалах тухай хуулийн Засгийн газрын бүрэн эрхэд заасан 13 дугаар зүйлийн 13.1.10-д “зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх”, Зэвсэгт хүчний тухай хуулийн Улсын Их Хурлын бүрэн эрхэд заасан 10 дугаар зүйлийн 10.1.4-д “зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэхэд зориулсан жил бүрийн төсвийг батлах” зэрэг эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангагдана;

2.Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн ашиглалт, засварыг технологийн горимын дагуу зохион байгуулах боломж, техникийн хадгалалтын нөхцөл сайжирч, бэлэн байдал дээшилнэ;

3.Зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникээр нөхөн хангах, сэргээн сайжруулах, галт хэрэглэл, сэлбэг, материал хэрэгслийн нөөц бүрдэнэ;

4.Батлан хамгаалахын аж үйлдвэрлэлийн суурийг тавих, хөгжүүлэх, технологийн инкубатор, туршилтын үйлдвэр, лаборатори, технологи дамжуулах төв, шинжлэх ухааны парк байгуулах, зарим төрлийн сум, галт хэрэглэл, зэвсэг, техник, тэдгээрийн эд ангийг зохион бүтээж, турших, зэвсэглэлд нэвтрүүлнэ.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай уялдсан байдал, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал:

"Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Төсвийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд тогтоолын төсөл батлагдсантай холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлага байхгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗЭВСЭГ, ТЕХНИКИЙГ ШИНЭЧЛЭХ, СЭРГЭЭН
САЙЖРУУЛАХ БОДЛОГЫГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо (Б.Энх-Амгалан)-нд даалгасугай.

Гарын үсэг

**"ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗЭВСЭГ, ТЕХНИКИЙГ ШИНЭЧЛЭХ,
СЭРГЭЭН САЙЖРУУЛАХ БОДЛОГО"**

**Нэг. Дэлхийн ба бүс нутгийн цэрэг-улс төрийн болон
цэрэг-стратегийн нөхцөл байдал**

Олон улсын цэрэг-улс төр, цэрэг-стратегийн нөхцөл байдал хурцдаж, хүйтэн дайны үеэс ч илүү сөргөлдөөнт байдалд хүрч, дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын орчинд шинэ сорилтууд бий болж байна. Эдгээр сорилтууд нь их гүрнүүд геополитикийн ашиг сонирхолдоо нийцүүлэн дэлхийн дэг журмыг шинээр тогтоох, бусад улсын оршин тогтнох аюулгүй байдалд илтээр заналхийлэх байдлаар илрэх боллоо.

Дэлхийн цэрэг-улс төрийн өөрчлөлттэй зэрэгцэн улс орнуудын цэрэг-батлан хамгаалахын зардал тасралтгүй нэмэгдэж, 2022 онд бодитоор 3.7 хувиар өсч түүхэн оргилд хүрээд байна. АНУ, ОХУ, БНХАУ 2022 онд дангаараа дэлхийн батлан хамгаалах зардлын 56 хувийг бүрдүүлж байжээ.

Дэлхийн цэрэг-стратегийн хямралт байдал ойрын жилүүдэд улам бүр хурцдах, улс орнууд батлан хамгаалах зардлаа эрс нэмэгдүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөх, тэр дундаа Төв болон Зүүн хойд Ази дэлхийн халуун цэг болох төлөвтэй.

Зүүн хойд Ази дахь их гүрнүүдийн улс төрийн бодлого нь АНУ-ын нөлөөллийн хүрээгээ тэлэх, БНХАУ байр сууриа бэхжүүлэх, ОХУ их гүрний байр сууриа эргүүлэн тогтоох гэсэн ашиг сонирхлын давхцал, зөрчилдөөнөөр илэрхийлэгдэж, нэг талаас Орос, Хятадын стратегийн иж бүрэн түншлэл, нөгөө талаас Америк, Япон, Солонгосын цэргийн харилцан ажиллагаа гэсэн хуваагдмал байдалд оруулаад байна. Үүний зэрэгцээ НАТО төлөөлөгчийн газраа Японд байгуулах яриа хэлэлцээр өрнүүлж байгаа нь ОХУ, БНХАУ-ын ашиг сонирхолтой зөрчилдөхөд хүргэж, БНАСАУ-ын цөмийн туршилт, баллистик пуужингийн харвалтын давтамж эрс нэмэгдэж байгаа нь тус бүс нутагт хурцадмал байдлыг улам даамжруулж байна. Энэхүү нөхцөл байдалтай уялдан АНУ цөмийн зэвсэг тээвэрлэгч шумбагч онгоцыг Солонгосын хойг орчимд тодорхой хугацаагаар байршуулахаар шийдвэрлэхэд хүргээд байна.

БНХАУ-ын БНСУ, Япон улсуудтай газар нутгийн болон усан хилийн маргаантай асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр байна. Хятадын Тайваний талаар баримталж байгаа бодлогоо цэргийн хүчээр хэрэгжүүлэх санаархал нь АНУ тэргүүтэй бусад улстай зөрчилдөхөд хүргэж байна. Хятад улс зэвсэгт хүчний байгуулалтын шинэчлэлээ 2035 он гэхэд бүрэн дуусгаж, энэ зууны дунд үе гэхэд Ардын чөлөөлөх армийг дэлхийн тэргүүлэх хүчний хэмжээнд хүргэх зорилготой байна.

Ази, Номхон далайн бүс нутаг цэргийн зэвсэглэл, техникийн нягтралаараа дэлхийн хамгийн их буюу дэлхийн хэмжээний зэвсэглэлийн 70 орчим хувийн

төвлөрлийг бий болгож байгаа нь Монгол Улсын цэрэг-улс төр, цэрэг-стратегийн гадаад орчны таатай бус байдлыг бий болгож болзошгүй.

Дэлхийн болон бүс нутгийн эдүгээгийн цэрэг-улс төр, цэрэг-стратегийн нөхцөл байдал нь Монгол Улсын Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, нэн тэргүүнд зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулахыг нөхцөлдүүлж байна.

Хоёр. Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл,
цэргийн техникийн өнөөгийн байдал

Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэлийн 93 хувийг буудлагын зэвсэг, 0,8 хувийг артиллер, миномёт, 0,4 хувийг зенит-артиллер, 3,4 хувийг хуягт техникийн зэвсэглэл, 2,4 хувийг танк эсэргүүцэх хэрэгсэл тус тус бүрдүүлж байна. Агаарын цэргийн онгоц, нисдэг тэрэг, агаараас довтолох хэрэгслээс хамгаалах зэвсэглэл агаарын хил, агаарын зайд хяналт явуулах техник, хэрэгсэл хангалтгүй хэвээр байна.

Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техник шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшингээс хоёроос дөрвөн үеэр хоцрогдсон, 75 хувь нь 35-45, түүнээс дээш жилийн ашиглалтын насжилттай, үйлдвэрлэгч оронд техникийн үйлдвэрлэл зогссон, галт хэрэглэл, тэжээлийн эх үүсгүүр болон бусад сэлбэг, дагалдах хэрэгслийн нөөц дутагдалтай, төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан ашиглалт, хадгалалтын технологийн горимыг алдагдуулж байна.

Зэвсэглэл, цэргийн техникийн дээр дурдсан өнөөгийн бодит байдал, нөлөөлж буй хүчин зүйлс нь Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх чадавхыг бууруулж байна.

Гурав. Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх,
сэргээн сайжруулах бодлогын чиглэл

3.1. Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1.хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн байх;

3.1.2.улсын төсөв, хөрөнгө оруулалтаар баталгаажсан байх;

3.1.3.шинжлэх ухааны ололт, инновац, дэвшилтэт технологид суурилсан байх;

3.1.4.нууцын горимын зохих шаардлагыг хангасан байх;

3.1.5.техник, технологийн ашиглалтын нийцлийг хангасан байх;

3.1.6.сум, галт хэрэглэл, цэргийн эд хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх боломжтой байх.

3.2.Зэвсэглэл, цэргийн техникийн ашиглалт, хадгалалтыг технологийн горимын дагуу зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж хэрэгжүүлэх чиглэлээр:

3.2.1.техникийн үйлчилгээ, хадгалалт, засварыг технологийн горимын дагуу зохион байгуулж, ашиглалтыг сайжруулна;

3.2.2. зэвсэглэл, цэргийн техникийн хадгалалтын нөхцөлийг дээшлүүлнэ;

3.2.3. цэргийн нэгтгэл, ангийн техникийн засвар, үйлчилгээний боломжийг нэмэгдүүлнэ;

3.2.4. зэвсэглэлийн галт хэрэглэл, цэргийн техникийн сэлбэг хэрэгсэл, шатахуун тосолгооны материалын нөөцийг бүрдүүлнэ.

3.3.Зэвсэглэл, цэргийн техникт төсвийн бодлогоор баталгаажсан төлөвлөгөөний дагуу сэргээн сайжруулах засвар, техникийн үйлчилгээ хийх чиглэлээр:

3.3.1.зэвсэглэл, цэргийн техникийг сэргээн сайжруулах засвар, техникийн үйлчилгээг жил бүр төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлнэ;

3.3.2.зэвсэглэл, цэргийн техникийн сэргээн сайжруулах хөрөнгийн зардлыг улсын төсөвт тусгана;

3.3.3.зэвсэглэл, цэргийн техникийн засвар-үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгох, их, дунд засвар хийх боломжийг бүрдүүлнэ.

3.4.Зэвсэглэл, цэргийн техникийг цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд гадаадын орнуудын зээл тусламжаар шинэчлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдаж авах чиглэлээр:

3.4.1.цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд удирдлага, холбоо, кибер аюулгүй байдал, РЭТ-ийн систем, төрлийн цэргийн үндсэн зэвсэглэл, тусгай зориулалтын техник хэрэгсэл, сум, галт хэрэглэлийг гадаадын орнуудын зээл, тусламжаар авч шинэчилнэ;

3.4.2.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэрэг, зэвсгийн удирдлагын систем, радио, радиотехникийн болон орон зайн тагнуулын техник, хэрэгсэл, агаараас довтлох хэрэгслээс болон танк эсэргүүцэх зөөврийн зэвсэглэл, нисдэг тэрэг, цэргийн болон тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, буудлагын зэвсэг, сум, галт хэрэглэлийг худалдан авч шинэчилнэ;

3.4.3.цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд гадаадын орнуудын зээл, тусламжаар зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх боломжгүй тохиолдолд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авна.

3.5.Дотоод нөөц бололцоондоо тулгуурлан орчин үеийн технологийн ололт, шийдлийг нутагшуулж, цэргийн зарим төрлийн техник, хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэх чиглэлээр:

3.5.1.гадаадын цэргийн зэвсэглэл, техникийн дэвшилтэт технологийг нутагшуулах замаар үндэсний батлан хамгаалахын аж үйлдвэрлэлийн суурийг тавьж, хөгжүүлнэ;

3.5.2. батлан хамгаалах эрх ашигт нийцсэн технологийн инкубатор, туршилтын үйлдвэр, лаборатори, технологи дамжуулах төв, шинжлэх ухааны парк байгуулна;

3.5.3. дотоод нөөц бололцоонд тулгуурлан нисэгчгүй нисэх хэрэгсэл, дрон, робот, холбооны радиостанц, радиолокацын станц, зэвсэг, техникийн эд ангийг зохион бүтээж, турших, зэвсэглэлд нэвтрүүлнэ.

Дөрөв. Зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо

4.1. Монгол Улсын Их Хурал:

4.1.1. Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогод нийцүүлэн тодорхойлно;

4.1.2. улсын нэгдсэн төсвийн батлан хамгаалах зардлын төсвийн ангилалд зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах зардлын ангиллыг тусгайлан бий болгож мөрдүүлнэ.

4.2. Монгол Улсын Засгийн газар:

4.2.1. зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах хөтөлбөр, төслийг баталж, хэрэгжүүлэх зардлыг жил бүр улсын төсөвт тусгана;

4.2.2. Зэвсэгт хүчинд шаардлагатай худалдан авах зэвсэглэл, цэргийн техникийн төрөл, тоог тогтоож, Улсын Их Хурлын зөвшөөрснөөр санхүүжүүлнэ;

4.2.3. цэрэг-техникийн хамтын ажиллагаатай гадаад улсын Засгийн газартай зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулна.

4.3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

4.3.1. зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах хөтөлбөр, төслийг Засгийн газарт өргөн мэдүүлнэ;

4.3.2. батлан хамгаалах зардлын жил бүрийн төсвийн төсөлд зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах зардлын саналыг тусгана;

4.3.3. Зэвсэгт хүчинд шаардлагатай худалдан авах зэвсэглэл, цэргийн техникийн төрөл, тооны талаарх саналыг Засгийн газарт хүргүүлнэ;

4.3.4. цэргийн аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр өндөр хөгжилтэй зарим орнуудтай технологи дамжуулах тухай гэрээ, хэлэлцээр байгуулан хамтран ажиллаж, эрдэм шинжилгээ, туршилт, судалгааг удирдлага, зохицуулалтаар хангана.

4.3.5. Зарим улс оронтой тодорхой төрлийн зэвсэг, техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах зорилгоор хамтарсан төсөл хэрэгжүүлж, хамтран ажиллана.

4.4.Зэвсэгт хүчний Жанжин штаб:

4.4.1.зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хэрэгжилтийг зэвсэгт хүчинд зохион байгуулна;

4.4.2.зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах нэгдсэн төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжилтийг хангана.

4.5.Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал:

4.5.1.төрлийн цэргийн зэвсэглэл, цэргийн техникийн бэлэн байдлыг хангана;

4.5.2.зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын хэрэгжилтийг төрлийн цэрэгт зохион байгуулна;

4.5.3.зэвсэглэл, цэргийн болон тусгай техникийн ашиглалт, засвар, хадгалалтыг төлөвлөж, хэрэгжилтийг хангана.

4.6.Зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл, анги:

4.6.1.зэвсэглэл, цэргийн техникийг хадгалах, хамгаалах, сэргээн сайжруулах арга хэмжээг гардан зохион байгуулна;

4.6.2.зэвсэглэл, цэргийн техникийг зориулалтын дагуу ашиглана.

ТАНИЛЦУУЛГА

"Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2023 оны н/07 дугаар "Төрийн цэргийн байгууллагуудыг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" зөвлөмж болон Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны мн/04 дүгээр тогтоолоор "Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2023 оны Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэхийг чиглэл болгосон.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дээрх шийдвэр нь Зэвсэгт хүчний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т "зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг тодорхойлох" гэж заасныг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд тул "Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын болон түүний хавсралтаар батлагдах бодлогын баримт бичгийн төсөл, холбогдох материалыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Олон улсын цэрэг-улс төр, цэрэг-стратегийн нөхцөл байдал хурцдаж, хүйтэн дайны үеэс ч илүү сөргөлдөөнт байдалд хүрч, дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын орчинд шинэ сорилтууд бий болж байна. Эдгээр сорилтууд нь их гүрнүүд геополитикийн ашиг сонирхолдоо нийцүүлэн дэлхийн дэг журмыг шинээр тогтоох, бусад улсын оршин тогтнох аюулгүй байдалд илтээр заналхийлэх байдлаар илрэх боллоо.

Олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлттэй холбогдуулан улс орнууд аюулгүй байдлын үзэл баримтлал, төрийн бодлогодоо батлан хамгаалах төсөв, зардлаа нэмэгдүүлэх, зэвсэглэл, техникийг шинэчлэх бодлогыг баримтлах болжээ.

Дэлхийн болон бүс нутгийн эдүгээгийн цэрэг-улс төр, цэрэг-стратегийн нөхцөл байдал нь Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, нэн тэргүүнд зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

Тухайлбал, ОХУ нь Украйнд цэрэг, дайны ажиллагаагаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ Зүүн хойд Азид геополитикийн ашиг сонирхол, нөлөөгөө хадгалахын тулд БНХАУ-тай иж бүрэн стратегийн түншлэлийн харьцааг бэхжүүлэх бодлого баримталж байна. Тус улс нь цэргийн зардлаараа АНУ-аас 10 гаруй дахин бага ч цэргийн хүчин чадлаараа дэлхийд тэргүүлэгчийн эгнээнд байх зорилгоо хадгалах үүднээс батлан хамгаалах төсвөө нэмэгдүүлж, 2022 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 3,2 хувийг эзэлж байсныг 2023 онд 4,7 хувьд хүргэсэн байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техник нь шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшингээс хоёроос дөрвөн үеэр хоцрогдсон, 75 хувь нь 35-45, түүнээс дээш жилийн ашиглалтын насжилттай, үйлдвэрлэгч оронд техникийн үйлдвэрлэл зогссон, галт хэрэглэл, тэжээлийн эх үүсгүүр болон бусад сэлбэг, дагалдах хэрэгслийн нөөц дутагдалтай, төсвийн хязгаарлагдмал байдлаас

шалтгаалан ашиглалт, хадгалалтын технологийн горимыг алдагдуулж байна. Тухайлбал, улсын нийслэл болон онц чухал объектыг агаараас довтлох хэрэгслээс хамгаалах зориулалттай "Печора-2М" С-125М загварын зенит пуужингийн цогцолбор нь техник, программ хангамжийн гэмтэлтэй тул засварлах, агаарын зайд хяналт явуулах зориулалттай радиолокацын станцын 90 хувьд сэргээн сайжруулах засвар, үйлчилгээ хийх, онгоц, нисдэг тэрэгний 36 хувийн ашиглалтын хугацааг сунгах хэрэгцээ байна.

Зэвсэгт хүчний байлдааны хуягт техникийн 53,3 хувь, байлдааны хангалтын техник, хэрэгслийн 38,0-76,8 хувь, цэргийн автотехникийн 50 хувийг сэргээн сайжруулах, хуягт техникийн 40,8 хувьд нь урсгал болон дунд засвар хийх, цэргийн автотехникийн 48,7 хувьд нь урсгал болон дунд засвар хийх шаардлагатай болсон.

Зэвсэглэлийн гол төмрийн элэгдлийн хэмжээ их, дуран, шөнийн харааны хэрэгслүүдийн 70 хувь нь механик болон цахилгааны гэмтэлтэй, сэргээн сайжруулах засвар, үйлчилгээ хийх хэрэгцээ, шаардлага үүссэн.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын баримт бичгийн эрх зүйн үндэслэл болж байна.

Улсын Их Хурлын тогтоолоор батлагдах энэхүү бодлогын баримт бичиг нь дэлхийн ба бүс нутгийн цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн нөхцөл байдал, Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн өнөөгийн байдал, Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын чиглэл, Зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо гэсэн 4 бүлгээс бүрдэнэ.

Бодлогын баримт бичиг батлагдсанаар хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлого, цэргийн урлагийн хөгжлийн чиг хандлага, Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэгт нийцсэн, шинжлэх ухааны ололт, инновац, дэвшилтэт технологид суурилсан өндөр бүтээмжтэй зэвсэглэл, цэргийн техникээр нөхөн хангагдах эрх зүйн болон төсөв, санхүүгийн үндэс бүрдэж, дараах эерэг үр дүнд хүрч, боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Үүнд:

1.Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 4.7-д заасан "Зэвсэгт хүчний зэвсэглэлийг үе шаттай шинэчилж байх уян хатан тогтолцоо бүрдүүлнэ. Цэргийн зэвсэг, техник худалдан авахад зориулан батлан хамгаалах зардлын тодорхой хэсгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байна.", Батлан хамгаалах тухай хуулийн Засгийн газрын бүрэн эрхэд заасан 13 дугаар зүйлийн 13.1.10-д "зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх", Зэвсэгт хүчний тухай хуулийн Улсын Их Хурлын бүрэн эрхэд заасан 10 дугаар зүйлийн 10.1.4-д "зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэхэд зориулсан жил бүрийн төсвийг батлах" зэрэг эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангагдана;

2.Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн ашиглалт, засварыг технологийн горимын дагуу зохион байгуулах боломж, техникийн хадгалалтын нөхцөл сайжирч, бэлэн байдал дээшилнэ;

3.Зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникээр нөхөн хангах, сэргээн сайжруулах, галт хэрэглэл, сэлбэг, материал хэрэгслийн нөөц бүрдэнэ;

4.Батлан хамгаалахын аж үйлдвэрлэлийн суурийг тавих, хөгжүүлэх, технологийн инкубатор, туршилтын үйлдвэр, лаборатори, технологи дамжуулах төв, шинжлэх ухааны парк байгуулах, зарим төрлийн сум галт хэрэглэл, зэвсэг, техник, тэдгээрийн эд ангийг зохион бүтээж, турших, зэвсэглэлд нэвтрүүлнэ.

Улсын Их Хурлын тогтоолоор батлагдах "Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого"-ын баримт бичигт үндэсний аюулгүй байдал, төрийн нууцтай холбоотой асуудлууд хөндөгдөх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлалуудыг 12.2.18-д заасны дагуу боловсруулах болон хуулийн 38 дугаар зүйлийн 38.8-д заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлагагүй болно.

Мөн "Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13-д "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой төрийн бодлогын баримт бичиг, гамшгийн болон онц, дайны байдлын үеийн төлөвлөгөө нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөлд хамаарахгүй бөгөөд энэ хуулиар зохицуулахгүй" гэж заасны дагуу тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан дарааллыг хэрэглээгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**"ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗЭВСЭГ, ТЕХНИКИЙГ ШИНЭЧЛЭХ, СЭРГЭЭН САЙЖРУУЛАХ
БОДЛОГЫГ БАТЛАХ ТУХАЙ" МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

"Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2023 оны н/07 дугаар "Төрийн цэргийн байгууллагуудыг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 07 дугаар зөвлөмж болон Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны мн/04 дүгээр тогтоол, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10-д "зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх" гэж заасан зэрэг юм.

Дэлхийн болон бүс нутгийн цэрэг-улс төр, цэрэг-стратегийн нөхцөл байдал хурцдаж, улс гүрнүүдийн хоорондоо сөргөлдөх байдал улам ихсэж, геополитикийн ашиг сонирхолдоо нийцүүлэн дэлхийн дэг журмыг шинээр тогтоох, бусад улсын оршин тогтнох аюулгүй байдалд илтээр заналхийлэх байдал улам нэмэгдэх хандлагатай байна.

Ийнхүү олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлт, дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын орчинд шинэ сорилтууд бий болсонтой холбогдуулан улс орнууд аюулгүй байдлын үзэл баримтлал, төрийн бодлогодоо батлан хамгаалах төсөв, зардлаа нэмэгдүүлэх болон зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогодоо ихээхэн анхаарч байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техник нь 35-45, түүнээс дээш жилийн ашиглалтын насжилттай, төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах үйл ажиллагаа хангалтгүй байгааг анхаарч, цэргийн урлагийн хөгжлийн чиг хандлага, Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэгт нийцсэн, шинжлэх ухааны ололт, инновац, дэвшилтэт технологид суурилсан өндөр бүтээмжтэй зэвсэглэл, цэргийн техникээр нөхөн хангах зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа болно.

Дээрх нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Зэвсэгт хүчнийг бэхжүүлэхэд шаардлагатай ямар зэвсэглэл, цэргийн техникийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдаж авах болон гадаадын улс орнуудаас буцалтгүй тусламжаар тэргүүн ээлжинд шинэчлэх, сэргээн сайжруулах зэвсэглэл, техникийг энэхүү бодлогын баримт бичгээр тодорхойлж өгч байгаагаар ач холбогдолтой юм.

Тус бодлогын баримт бичиг нь бүтцийн хувьд дэлхийн ба бүс нутгийн цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн нөхцөл байдал, Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн өнөөгийн байдал, Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогын чиглэл, Зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо гэсэн 4 бүлгээс бүрдэхээр боловсруулагдсан болно.

"Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлал болон "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь Зэвсэгт хүчнийг бэхжүүлж, чадавхжуулах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээтэй нийцэж байгаа болно.

Мөн “Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13-д заасныг үндэслэн тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан дарааллыг хэрэглээгүй болно.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

**"ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗЭВСЭГ, ТЕХНИКИЙГ ШИНЭЧЛЭХ, СЭРГЭЭН САЙЖРУУЛАХ
БОДЛОГЫГ БАТЛАХ ТУХАЙ" УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ
ХЭЛЭЛЦЭХЭД ОРОЛЦОХ АЛБАН ТУШААЛТНЫ НЭР**

1. Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр /9410-0050/;
2. ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Сүнрэвийн Ганбямба /9926-1912/;
3. БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Давгадоржийн Ганхуяг /9909-1170/;
4. БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Чулуунборын Гандирваа /9999-1256/;
5. БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга, хуулийн зөвлөх, хурандаа Гомбосүрэнгийн Энхболд /9665-4413/.
6. ЗХЖШ-ын Материал, техникийн газрын дарга, хурандаа Б.Түвшинтөр /8811-2903/.

---oO---